

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 52 дугаар тушаал, Зам, тээврийн сайдын 2015 оны 113 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

## АВТО ЗАМЫН НОРМ, НОРМАТИВЫН САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Авто замын норм, нормативын сан /цаашид “Сан” гэх/-гийн журмын зорилго нь Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсгийг хэрэгжүүлж, салбарын норм, норматив, стандарт, техникийн баримт бичгийн судалгаа хийх, боловсруулах, батлуулах, хэвлэж, олшруулах, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Сангийн удирдах зөвлөлийн баталсан төлөвлөгөөний дагуу авто замын салбарын норм, норматив, стандарт, техникийн баримт бичгийг боловсруулах, батлуулах ажлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллана.

1.3. Сангийн хөрөнгөөр авто замын норм, норматив, стандарт, техникийн баримт бичиг боловсруулахад Авто замын судалгаа, шинжилгээ, хөгжлийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, авто замын барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэдийг оролцуулах зарчмыг баримтална.

1.4. Сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, сурталчлах ажлыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулна. Сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

1.5. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын баримтад авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд захирагч нэгдүгээр, тус байгууллагын ерөнхий нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг тус тус зурна.

1.6. Сангийн хөрөнгө зарцуулалттай холбогдсон анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг байна.

### Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь 7-9 гишүүнтэй байна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.2. Удирдах зөвлөлийн дарга нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга байна.

2.3. Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. Авто замын салбарын норм, норматив, стандарт, техникийн баримт бичгийг боловсруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, жишиг үнэлгээ тогтоох;

2.3.2. Сангийн үйл ажиллагааны дунд хугацааны болон жилийн төлөвлөгөө, төсвийг хянан хэлэлцэж батлах;

2.3.3. Авто замын норматив баримт бичгийг боловсруулалтын явцыг хэлэлцэж, эрчимжүүлэх, шаардлагатай арга хэмжээг авах;

2.3.4. Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг хэлэлцэн дүгнэх.

2.4. Удирдах зөвлөл нь сангийн тухайн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэн ирэх оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дараа оны нэгдүгээр улиралд багтаан баталсан байна.

2.5. Удирдах зөвлөлийн хуралдаан нь бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй гишүүний ирцтэй хуралдаж, олонхийн саналаар шийдвэр гаргана.

2.6. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, түүнийг Удирдах зөвлөлийн дарга баталгаажуулна.

2.7. Удирдах зөвлөлийн дарга дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.7.1. Сангийн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийг томилуулах, өөрчлөх цалин урамшууллыг тогтоох талаар санал боловсруулж, авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

2.7.2. Авто замын норм, норматив, техникийн баримт бичгийг ач холбогдлоор эрэмбэлэх, боловсруулах дарааллыг тогтоох, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, хяналт тавьж, эрчимжүүлэх;

2.7.3. Сангийн үйл ажиллагааны дунд хугацааны болон жилийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.7.4. Сангийн зорилго, үйл ажиллагаатай холбогдох асуудлаар иргэн, хуулийн этгээдтэй гэрээ, хэлэлцэл байгуулах, дүгнэх;

2.7.5. Сангийн хөрөнгө бүрдүүлэлт, зориулалт, зарцуулалтын талаар илэрсэн зөрчил, дутагдлыг цаг тухайд нь арилгуулах.

2.8. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

2.8.1. Сангийн үйл ажиллагааны дунд хугацааны болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайлан улирал тутам гаргаж, дараа сарын 05-ны өдрийн дотор Удирдах зөвлөлд хүргүүлэх;

2.8.2. Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг болон энэ журамд заасны дагуу Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Сангийн хөрөнгийг зарцуулах;

2.8.3. Сангийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхээр сонгон шалгаруулсан этгээдтэй гэрээ байгуулах, дүгнэх;

2.8.4. авто замын норм нормативын бичиг баримтыг боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, үндсэн чиглэл, хөтөлбөр боловсруулах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад орны туршлагыг судлан шаардлагатай норм норматив, стандарт, техникийн баримт бичгийг худалдан авах;

2.8.5 Санд хөрөнгө төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

2.8.6. авто замын норм норматив, стандарт, техникийн баримт бичгийг батлахтай холбогдуулан боловсруулсан судалгааны ажил, норм, дүрэм, стандартын төсөлд зохих байгууллагаар шүүмж, редакц хийлгэх, санал дүгнэлт гаргуулах, тэдгээрийг хадгалах;

2.8.7. Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг бэлтгэж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.8.8. Санд хөрөнгө төвлөрүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн байгууллагын төлбөрийг нөхөн төлүүлэх.

2.9. Авто замын судалгаа, шинжилгээ, хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

2.9.1. авто зам, замын байгууламжийн норм норматив баримт бичгийг боловсруулах сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

2.9.2. Авто зам, замын байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх, зарцуулах талаар санал боловсруулж, Удирдах зөвлөлд хүргүүлэх;

2.9.3. авто замын норм норматив, техникийн баримт бичиг болон түүнтэй холбогдсон материалаар фонд, мэдээллийн сан үүсгэх, баяжуулах;

2.9.4. салбарын хууль тогтоомж, авто замын норм норматив, стандарт, техникийн баримт бичгийн жагсаалт, эмхэтгэлийг хэвлүүлэх, нийтэд түгээх, сурталчлах;

2.9.5. батлагдсан төлөвлөгөөний хүрээнд авто замын норм норматив, техникийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай ном, хэвлэл, аргачлал, заавар, тоног төхөөрөмж, материал худалдан авах, цахим сан бий болгох, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр туршлага судлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

2.9.6. Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дах хэсэгт заасан чиг үүргийг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх.

### Гурав. Санд хөрөнгө төвлөрүүлэх

3.1. Сан нь Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Хуулийн этгээд, иргэн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тухайн жилд гүйцэтгэсэн авто замын барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгөөс 0.4 хувиар тооцож, тухай бүр Сангийн дансанд төвлөрүүлнэ.

3.3. Авто асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Санд төвлөрүүлэх хөрөнгийн ногдуулалт, төлөлтийн тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнана.

#### Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалт

4.1. Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зориулан зарцуулна:

4.1.1. Сангийн үйл ажиллагааны зардал;

4.1.2. норм норматив баримт бичгийг судлах, шүүлт хийх, боловсруулах, редакц, шүүмж хийлгэх, шинжээчээр хянуулах зардал;

4.1.3. салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хуулийн төсөл, дүрэм, журмыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардагдах зардал;

4.1.4. хуулийн болон норм, норматив, техникийн баримт бичгийн талаар олон улсын туршлагыг судлах, гадаад, дотоодын сургалтад хамрагдах зардал;

4.1.5. норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичгийг эмхэтгэн хэвлүүлэх, сурталчлах зардал;

4.1.6. норм норматив, стандарт, техникийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай ном, хэвлэл, аргачлал, заавар, тооцоо судалгааны болон бусад материал, тоног төхөөрөмж, худалдан авах зардал;

4.1.7. олон улсын мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах зардал;

4.1.8. салбарын норм норматив, стандарт, техникийн баримт бичгийг боловсруулахтай холбоотой хурал, зөвлөгөөн, сургалт, семинарыг зохион байгуулах зардал;

4.1.9. норм норматив, стандарт, техникийн баримт бичгийг боловсруулах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд шаардагдах зардал;

4.1.10. норм норматив, стандарт, техникийн баримт бичгийн төслийг Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөл, стандартчиллын техникийн хороодоор хэлэлцүүлэх зардал;

4.1.11. Удирдах болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүний цалин урамшууллын зардал.

4.2. Сангийн хөрөнгийг хууль болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, дараах чиглэлийн арга хэмжээнд зарцуулахыг хориглоно:

4.2.1. байгууллага, хувь хүнийг ивээн тэтгэх, хандив өргөх

4.2.2. байгууллага, аж ахуйн нэгжийн алдагдал нөхөх, баталгаа гаргах

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих

5.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох санхүү, стандарт, нормативын нэгжүүд сангийн хөрөнгө бүрдүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг Удирдах зөвлөлд танилцуулна.

5.2. Тухайн жилд боловсруулах норм, стандарт, техникийн баримт бичгийн төлөвлөгөөг яамны Вэб сайтад байршуулж, түүний хэрэгжилтийг талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.3. Сангийн хяналтын зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн гишүүн батална.

5.4. Сангийн хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад жилд нэгээс доошгүй удаа хяналт шинжилгээ хийж тайланг Удирдах зөвлөлд танилцуулна.

--oOo--